



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/108

Хажуу шинэ ус

Газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 35.1.4 дэх заалт, 38.1, 38.2, 38.4 дэх хэсэг, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Говь-Угтаал сумын 2 дугаар багын нутаг дэвсгэр (Өвдөгийн улаан)-д байршилтай иргэн Баярсайханы Очирбат (ЗВ84121636)-ийн өвөлжөө хаваржааны зориулалттай 4807001118 нэгж талбарын дугаартай 5000 м.кв (0.5 га) газрыг иргэн Эрдэнэ-Очирын Алтаншагай (ЗВ91012713)-т зориулалтаар нь шилжүүлж 14 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Дээрх газрын эзэмшигч Э.Алтаншагай эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгох, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Н.Лхагва-Учрал)-д, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Т.Цэрэнчунт)-д үүрэг болгосугай.

3.Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу ашиглаж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигч (Э.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2024 оны А/94 дүгээр захирамжийн иргэн (Б.Очирбат)-д холбогдох хэсэг мөн газар эзэмших эрхийн 000036611 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.ДОРЖСҮМБЭР

482501008

